

ОЮУ ТОЛГОЙН ТУХАЙ ТОВЧХОН




■ Оюу Толгой нь Монгол Улсын өмнөд хэсэг, Өмнөговь аймагт нийслэл Улаанбаатар хотоос 600 километр зайд орших дэлхийн хамгийн том ашиглалтад бэлтгэж буй алт, зэсийн орд юм.



■ Оюу Толгойн олборлолт 2012 онд ил уурхайгаас эхлэх бөгөөд жилд 450,000 тонн зэс, 330,000 унц алт үйлдвэрлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна. Ингэснээр дэлхийн томоохон зэс, алтны уурхайн нэг болно.



■ Оюу Толгой нь Монгол Улсын Засгийн газар, Айвенхоу Майнз болон Рио Тинто группын хамтарсан компани юм. Энэхүү төслийг Рио Тинто 2010 оны 10 дугаар сараас удирдаж эхэлсэн бөгөөд тус компани нь Айвенхоу Майнзын хувьцааны 48,5%-ийг эзэмшдэг.



Хаягдал өтгөрүүлэгч байгууламж



БАРИМТЫН ТОВЧООН

БАЙГАЛЬ ОРЧНЫ СТАНДАРТУУД

- Оюу Толгой төсөл дээр хараат бус Эдийн засгийн нөлөөллийн үнэлгээ хийгдсэн бөгөөд уурхайн баримтлан мөрдөж буй аюулгүй ажиллагаа, байгаль орчны бодлого нь Дэлхийн банкны стандартуудад бүрэн нийцэж, дэлхий даяар хэрэгжиж буй ижил төрлийн төслүүдтэй эн зэрэгцэж буй юм.
- Оюу Толгой нь өөрийн усны хэрэгцээг Гүний хоолой дахь гүний усны нөөцөөс хангаж байна. Энэхүү ус нь унданд тохирохгүй ус бөгөөд ундны усны нөөцөөс тусдаа юм. Оюу Толгой нь энэхүү гүний усны нөөцийн 25%-ийг ашиглах зөвшөөрөлтэй тул гүний ус бүрэн шавхагдахгүй. Уурхайд хэрэглэж буй бүх усыг дахин эргүүлэн ашиглах ба дахин боловсруулсан ус нь нийт хэрэглээний 80%-ийг эзлэх болно. Оюу Толгой нь өөрийн үйл ажиллагаанаас гарч буй хаягдал усыг тэг хэмжээнд байлгах зорилтыг хэрэгжүүлж эхэлсэн.
- Оюу Толгойн хөрөнгө оруулагчид уурхайн үйл ажиллагаа дуусахад тус газар нутгийг нөхөн сэргээх бүрэн эрмэлзэлтэй байгаа.





Оюу Толгой ХХК
Моннис цамхаг
Чингисийн өргөн чөлөө-15
Сүхбаатар дүүрэг
Улаанбаатар - 14240

Олон нийттэй харилцах хэлтэс
Утас: +976 11 331880
Факс: +976 11 331893
И-мэйл: OTLLCinfo@ot.mn
www.ot.mn